

ТҮР ИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

П.Гансүх

Үндэсний тагнуулын академийн багш

Товч агуулга: Түрийн болон албаны нууцын тухай шинээр батлагдсан хууль нууцтай холбоотой бүх харилцааг бүрэн зохицуулах чадамжтай байх ёстой. Хуулийг тус тус тэйгээр хэрэглэхий, хууль ёсны байх гэсэн хуулийн зарчим дээрх хуулийн зарим нэг заалтад зөрчилтэй, тодорхой бус тусгагдсан нь энэхүү судалгааны зорилгыг тодорхойлж байна.

Түлхүүр үгс: нууц, түрийн болон албаны нууц, нууцын зэрэглэл, эрх бүхий албан тушаалтан, нууцын устгалт, засварлалт

Оршил

Монгол Улсад анх 1995 онд Түрийн нууцын тухай хууль, Түрийн нууцын жагсаалтыг батлах тухай хууль батлагдсан ба 2001,2003,2004, 2014, 2020 онуудад нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт орж шинэчлэн найруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 17-д "Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж эл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" ¹⁸, Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Тагнуулын ерөнхий газрын үүрэг, 11.1.6. "Түрийн болон онц чухал мэдээллийн сэлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх", 11.1.11 "Түрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах" гэж заасан¹⁹ нь нууцтай холбоотой харилцааг хууль эрх зүйн орчинд тодорхой түвшинд бий болгосон байна.

Нөгөө талаар хүний суурь эрхийн нэг болох "мэдэх", хараат бус хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хуулийн хүрээнд баталгаажуулах, зохицуулах харилцаа байх ёстой.Иргэн мэдээлэл олж авах чадвартай (боломжтой) байх нь ардчиллын Үндсэн зарчим.Ардчиллын мөн чанар нь нийгмийн гишүүд төлөөллөөр сонгогдсон хэсгээрээ төр бариулан тэдний үйл ажиллагаанд идэвхтэй оролцон хяналт тавих, хариуцлага тооцох юм.Үүнийг мэдээлэлгүйгээр гүйцэтгэх боломжгүй.Нууцын тухай ойлголт, нууцын тухай хуульд хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор гэсэн томъёоллууд нь задруулбал Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй мэдээллүүдийг хамруулахаар заасан.

¹⁸.Монгол Улсын Үндсэн хууль.Түрийн мэдээлэл. 1992 он.№1.

¹⁹.Тагнуулын байгууллагын тухайхууль. Түрийн мэдээлэл.1999 он.№35

Ямар ч байсан нууц гэх асуудал нь цаг үеийн шаардлагаар хувьсаж өөрчлөгдөж шинэчлэгдэж байгаа нь судлах шаардлагатай уялдаж тухайн асуудлын эерэг болон сөрөг үр дагаврыг шийдвэрлэх, хор уршгийг багасгах чиг хандлагатай байх ёстой гэж үзэж байна. Ингэснээр хэргийн эрх, эрх чөлөөг хангах, төрийн нууцыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг зөв үр тогтоох юм. Сөрөг үр дагавар юугаар ч нөхцөлийн нийгэм (цаг хугацаа), эдийн засгийн хохирол, эерэг үр дагавар тэнцвэртэй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байхаар тодорхойлогдоно.

Төрийн нууцын тухай хуульд орсон дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь зарчмын шинжтэй бус, шинээр батлагдсан хууль тогтоомжтой уялдуулж нэр томьёо, тодорхой зүйл, заалтыг өөрчлөх, нэмэх, хуулийн хэрэгжилтийн явцад өссөн зарим асуудлыг тодотгох, зөрчил, шийтгэлийн хэмжээг шинэчлэх зэрэг цаг үеийн хэрэгцээ, шаардлагаар нөхцөлдсөн. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн шинэчилсэн найруулга нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичгийн хэрэг хумьж, харьцангуй тодорхой болгосон боловч нэр томьёо, агуулгын хувьд зарим хэсэг заалт тодорхой бус зохицуулалтгүй, нууцын зэрэглэл, хугацааны хувьд боловсронгуй бус байсан нь баримт бичгийн, харьцуулалтын аргаар хийсэн судалгаанаас харагдаж байна. Харин 2020 оны 1 сард оруулсан нэмэлт өөрчлөлтүүр тодорхой хэмжээнд засварласан байна.

Нэг. Хуулийн нэр томьёо, хуулийн заалт

Төрийн нууцын тухай ойлголтыг Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар" толь бичигт "Олонд задруулахгүй, үзүүлэхгүй далдалбал зохих юм"²⁰ Б.Баярсайхан "Монгол хэлний хураангуй тайлбар" толь бичигт "Нийтэд үзүүлж, мэдэгдэж болохгүй далдалбал зохих тэр зүйлийг ойлгоно"²¹ гэж тайлбарлажээ.

Нууцын үндсэн шинж өргөдөл мэдээ мэдээлэл агуулдаг, хязгаарлагдмал хэрэвний итгэмжлэгдсэн хэргийн мэдэх шаардлагатай мэдээлэл байдаг. Задруулж болохгүй мэдээлэл (ил болгохгүй), мэдээллийг задруулбал таагүй үр дагавар бий болгоно (мчлэгч, эзэмшигч, ашиглагч болон бусад этгээдэд эд материалын болон ёс суртахууны хохирол учруулна), мэдээллийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд нь төрнийг хадгалах, хамгаалах хууль эрх зүйн үүрэг хүлээнэ, мэдээллийг задруулсан тохиолдолд хүлээх хариуцлагыг хуулиар тогтооно. Онолын үүднээс нууцыг хууль ёсны, байгууллагын, төрийн гэж төрөлжүүлэн тодорхойлж хуульчлан баталж байсан.

"Байгууллагын нууц гэж хэргийн эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйл"

"Төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг агуулж байгаа мэдээ, баримт, эд зүйл, объект, үйл ажиллагаа"

²⁰Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь.

²¹Б.Баярсайхан. Монгол хэлний хураангуй тайлбар толь.

Хуулиар зохицуулагдах хэрэгэнд шинээр тооцож болох гэмт хэрэг, нууц үйлдэл, задруулахаас үрээр шууд санаа зорилготойгоор нууцыг устгах, засварлах үйлдэл, эс үйлдэл нь зохицуулалт нэхэж байдаг. Мэдээж зохицуулалт байхгүйгээс хуулийн хийдэл үзэх, үүнээс хамаарч хамгаалалт сулрах аюул бий болох юм.

А. Эрх зүйн актууд

Энэ ойлголт 1935 оноос эхлэн 1945, 1955, 1964, 1999 онуудад нууцтай холбоотой тогтоолууд гарч эхэлсэн байна. Эдгээр тогтоолд улс төр-үзэл суртлын шинжтэй, цэрэг, хүн ам, эдийн засаг, бусад гэх мэтээр ангилсан байдаг.

"Улсын нууц болж тусгайлан хамгаалагдах мэдээн-үйдийн жагсаалт"²²-ыг баталсан нь улсын нууцыг тогтоосон анхны акт болжээ. Үүнээс үмн зүвх үн хэвлэлд нийтлэх, радиогоор нэвтрүүлэхийг шууд хориглох үйллийн жагсаалтаар мэдээлэлд хяналт тавьдаг байжээ. Улсын нууцын нууцын зэрэглэл "маш нууц-онц чухал, маш нууц, нууц" гэж 1964 оны 5 дугаар сарын 22-ны үдрийн 258 дугаар тогтоолоор тогтоосон. Энэ тогтоол 1992 он хүртэл үйлчилж байгаад Монгол Улсын шинэ үндсэн хуулийн агуулга, зарчим, эдийн засаг, нийгмийн харилцааны шинэчлэл, үүрчлүтийн бодлогод нийцүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 9 дүгээр сарын 25-ны үдрийн 38 дугаар тогтоолоор хүчингүй болсон ч нууцын зэрэглэлийн томъёолол нь одоо ч хэрэглэгдсээр байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Түрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.5-д "Нууцын зэрэглэлгэж Түрийн болон албаны нууцад хамааруулсан мэдээлэлтэй танилцах, эсхүл түний дагалдах баримт бичигт тавьсан тэмдэглэгээг". Мүн хуулийн 16 дугаар үйлд "Түрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түний шалгуур" 16.1-д "Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхол, байгууллага, иргэнд учруулах аюул занал, хохирлын хэмжээнээс хамаарч түрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл дараах зэрэгтэй".

16.4.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээллийг "онц чухал нууц" зэрэглэлд хамааруулна.

16.5.Задруулах үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах хүчин чадлыг сулруулах мэдээллийг "маш нууц" зэрэглэлд хамруулна.

16.6.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон түрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл түрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нүхцүл бий болгох мэдээллийг "нууц" зэрэглэлд хамруулна.

Энэ хуульд зааснаас үүр нууцын зэрэглэл хэрэглэхийг хориглоно, нууцын зэрэглэл тогтоох журмыг Засгийн газар батална гэж 16.3, 16.7. дугаар үйлүүдэд тус тус заасан байдаг.

²² 1945 оны 7 дугаар сарын 27-ны үдрийн БНМАУ-ын СнЗ-ийн 51- дүгээр тогтоол

Эрүүгийн хуульд:

19.11. дүгээр зүйл. Төрийн нууцыг хууль бусаар олж авах

Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлсийг хулгайлсан, цуглуулсан нь эх орноос урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хэргтэл хугацаагаар зорчих эрхийг нь хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хэргтэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

19.12. дугаар зүйл. Төрийн нууцыг задруулах

Төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хэргтэл хугацаагаар эрх хасах нэг жилээс таван жил хэргтэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хэргтэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

-Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал-маш нууцыг задруулсан бол:

19.13. дугаар зүйл. Төрийн нууцыг үрэгдүүлэх

Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хэргтэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хэргтэл хугацаагаар хорих ял шийтгэнэ²³.

Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал-маш нууцыг үрэгдүүлсэн бол:

Зөрчлийн тухай хуульд:

15 дугаар бөмлөг, Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил

15.14 дүгээр зүйл. Төрийн нууцын тухай хууль зөрчих

1.1. Хуульд заасан

1.2. Төрийн нууцад хамааруулах,

1.3. Төрийн нууцтай танилцах,

1.4. Төрийн нууцлах, эсхүл ил болох,

1.5. Төрийн нууцыг шилжүүлэх эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаарх тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

2. Төрийн нууцад үл хамаарах мэдээлэл нууцалсан, эсхүл хувийн зорилгоор ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох²⁴.

Б. Эрх зүйн актуудын зөрчил

²³ Эрүүгийн хууль.Төрийн мэдээлэл.2016 он. №21

²⁴ Зөрчлийн тухай хууль.Төрийн мэдээлэл.,2017 он.№41

Тухайн цаг өдөө хэрэгжиж байсан хууль, тогтоомжууд нь асуудлыг шийдвэрлэж ирсэн ч бэрэн дөрөн зохицуулж байгаагүй нь ойлгомжтой.

Одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйл. Төрийн нууцыг задруулах

-Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал-маш нууцыг задруулсан бол:

19.13 дугаар зүйл. Төрийн нууцыг үргэлжлэх

-Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал-маш нууцыг үргэлжлэсэн бол- гэсэн заалтууд нь

1.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16 дугаар зүйл: Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, төрний шалгуур гэсэн зүйлд зааснаар

онц чухал нууц

маш нууц

нууц гэсэн зэрэглэлтэй байхаар хуульчлан тусгасан нь зөрчилтэй заалт болсон.

2.Эрүүгийн хуульд Төрийн нууцыг задруулах, үргэлжлэх гэж томъёолсон нь шинээр мөрдөгдөж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албаны нууцыг задруулах үргэлжлэх тохиолдолд заагдаагүй.

Эрүүгийн хуульд заагдаагүй үйлдэл эс үйлдэл гэмт хэрэгт тооцогдохгүй. Хэрэв хуулийн нэр томъёоллын үнднээс бус "нууц"-ыг ш хонзон, албан тушаалын бусад сэдлээр нууцын материалыг устгах, засварлах үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй бол цаашид **хуулийн практик, амьдралд мухардал үүсэхээр байна.**

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 27 дугаар зүйл. Албан тушаалтан иргэний үүрэг: Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, иргэн дараах үүрэг хүлээнэ.

27.1.6. Хуульд үүрэг заагаагүй бол хувийн хэргээр гадаад улсад зорчих тохиолдолд байгууллагадаа урьдчилан бичгээр мэдээлэх.

Хуулиар заасан нөхцөлөөс үүр нөхцөлд нууц мэдээлэлтэй танилцах албан тушаалтан, иргэн хувийн биш албан хэргээр гадаад улсад зорчихдоо хэрхэх нь мөн хуульд тодорхойгүй байна.

Хоёр. Анхаарах зарим асуудал

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн зүйл заалтанд байгаа нэршил, томъёоллыг тодорхой, нэг мөр болгож нэгдсэн ойлголт бий болгох. Нууцтай холбоотой гарч болох гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хуульчлах. Нууцыг нууцлах эрх бүхий субъектын харьцааг зөв тогтоох. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 2 дугаар бүлэг, 8 дугаар зүйл. ²⁵ Улсын их хурлын бэрэн эрх, 8.1.1. "Төрийн болон албаны нууцыг

²⁵ Төрийн болон албаны нууцын тухай хууль., 2017 он. №25

хамгаалах түүрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих" гэсэн заалт нь тус хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын бэрэн эрх, нууцыг ил болгох заалт нь нндсэн хуульд түүрийн нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасантай л нийцэж байгаа нь анхаарал татаж байна. Үүрх хэлбэл нууцынзэрэглэлийг тогтооход Улсын Их Хурал хуулиар, харин Засгийн газрын шийдвэрээр (тогтоол) ил болгож шийдвэрлэх нь зрчилтэй.

Түүрийн нууц гэдэг нь үүрх хуулиар эрх олгогдоогүй субъект буюу үүрх этгээдэд задруулж болохгүйг хуулиар хориглон хамгаалсанбичиг баримт, эд зүйл, үйл ажиллагаа, объект, мэдээллийн нууц эх сурвалжийг тус тус багтаасан ойлголт юм.үүнийг зарим гадаад улсын холбогдох хуульд тусгасан байдаг.

Дүгнэлт

Шинээр батлагдсан Монгол Улсын Түүрийн болон албаны нууцын тухай хуулийг үүн мрдж байсан Түүрийн нууцын тухай хуультай харьцуулахад зохицуулалт, тодорхойлолт гэх мэт асуудлыг тодорхой хэмжээнд тусгасан дэвшилттэй байгаа ч сэдвийн хрээнд хуулиудыг харьцуулан зэхэд дараах дүгнэлтэнд хрч байна.

Шинээр батлагдсан хуульд нууцын зэрэглэл нь Эрүүгийн хуульд ойлгомжгүй тусгагдсан (зрчилтэй).Түүрийн болон албаны нууц (нууц, маш нууц, онц чухал нууц) нь хуульд заагдсан зэрэглэлийг тусгаагүй.

Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шинээр хуульчлан шаардлагатай зохицуулалт хийгдээгүй (Түүрийн болон албаны нууцыг устгах, засварлах үйлдэл эс үйлдлийг гэмт хэрэгт тооцох)

Албаны нууцыг ррегдлэх, задруулах үйлдэл эс үйлдлийн талаар 2020 оны 1 сард хийгдсэн нэмэлт үүрхлтс үүн тус хуульд зохицуулалт байгаагүй.

Нууцтай харилцагч албан тушаалтан, иргэн гадаад улсад зорчих заалт учир дутагдалтай (зүх н хувийн хэргээр зорчих тохиолдолд гэж заасан)

Хуулиар нууцыг нууцлах хуулийн зохицуулалтыг ндсэн хуулийн заалтыг баримтлан хуулиар нууцлах ил болгох гэсэн заалтууд нь учир дутагдалтай байна. УИХ-аар хуульчлан нууцыг ил болгох зохицуулалт оруулах.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын ндсэн Хууль.Түүрийн мэдээлэл. №1.1992.
- Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай хууль.Түүрийн мэдээлэл.1999. №35
- Монгол Улсын Эрүүгийн хууль. Түүрийн мэдээлэл. 2016. №21
- Монгол Улсын Зрчлийн тухай хууль.Түүрийн мэдээлэл. 2017. №41
- Монгол Улсын Түүрийн болон албаны нууцын тухай хууль. Түүрийн мэдээлэл. 2017.№25